

Российская академия наук
Институт восточных рукописей
(Азиатский Музей)



Адрес учредителя: 191181,
г. Санкт-Петербург,
Дворцовая наб., д. 18.

Адрес редакции: 191181,
г. Санкт-Петербург,
Дворцовая наб., д. 18.

Адрес издателя: 191181,
Санкт-Петербург,
Дворцовая наб., д. 18.

Тел.: +7 (812) 315-87-28
<http://orientalstudies.ru>
mongolica@orientalstudies.ru
kulgan@inbox.ru
dnosov@mail.ru

Регистрационный номер
свидетельства о регистрации
средства массовой информации
ПИ No ФС77-79202
от 22 сентября 2020 г.

ISSN 2311-5939

DOI 10.48612/IVRRAN/u242-79fv-7bdr

MONGOLICA

Санкт-Петербургский журнал монголоведных исследований

Том XXVIII • 2025 • № 2

Выходит 4 раза в год

Издается с 1986 г.

Учредитель: ФГБУН

Институт восточных рукописей РАН

Редакционная коллегия:

И. В. Кульганек, *главный редактор,*
доктор филологических наук (Россия)

Д. А. Носов, *секретарь редколлегии, кандидат*
филологических наук (Россия)

М. А. Козинцев, *помощник секретаря,*
кандидат исторических наук (Россия)

Г. Билгуудэй, *доктор филологических наук (Монголия)*

А. Бирталан, *доктор наук (Венгрия)*

Р. М. Валеев, *доктор исторических наук (Россия)*

Л. С. Дампилова, *доктор филологических наук (Россия)*

И. В. Зайцев, *доктор исторических наук, профессор РАН*
(Россия)

Ж. Легран, *доктор наук, профессор (Франция)*

В. Капишовска, *доктор наук (Чехия)*

Э. Мунхцэцэг, *кандидат филологических наук*
(Монголия)

С. Л. Невелева, *доктор филологических наук (Россия)*

К. В. Орлова, *доктор исторических наук (Россия)*

М. П. Петрова, *кандидат филологических наук (Россия)*

Р. Поп, *доктор наук (Румыния)*

Ц. Саранцацрал, *доктор филологических наук*
(Монголия)

Т. Д. Скрынникова, *доктор исторических наук, профессор*
(Россия)

С. Чулуун, *академик МАН (Монголия)*

Е. Э. Хабунова, *доктор филологических наук (Россия)*

Н. Хишигт, *кандидат исторических наук (Монголия)*

Н. С. Яхонтова, *кандидат филологических наук (Россия)*

Оригинал-макет – М. В. Алексеева

Литературные редакторы и корректоры – Д. А. Носов, И. В. Кульганек

Технический редактор – М. А. Козинцев

Подписано в печать 15.06.2025

Формат 60×90 1/8. Объем 10 печ. л. Заказ №

Тираж 300 экз.

Отпечатано в типографии ООО «Литография».

Адрес типографии: 191119, Санкт-Петербург, ул. Днепропетровская, д. 8,
лит. А, офис 14.

e-mail: info@litobook.ru

12+

© Институт восточных рукописей РАН
(Азиатский Музей), 2025

© Коллектив авторов, 2025

В НОМЕРЕ:

ФИЛОЛОГИЯ

Д. Гэрэлмаа. 18 дугаар зууны ноёд, тайж, лам нарын захидлуудын Үгсийн санг ажиглах нь.....	5
Ли Цинцзе. Изучение героического эпоса о Гэсэре советскими и российскими исследователями в XX веке.....	13
Э. Мөнхцэцэг. Монгольский толковый словарь Б. Буянчулгана (1930 г.)	20
Н. С. Яхонтова. Термин <i>törö</i> в монгольской и ойратской версиях «Истории Усун Дэбэсгэртү-хана»	28
Л. А. Федотова, И. Н. Храпова, Н. В. Ямпольская. Буддийские артефакты в собрании Центральной научно-технической библиотеки по строительству и архитектуре»	38

СМЕЖНЫЕ ДИСЦИПЛИНЫ

И. А. Алимов. «Дун Цзин Мэн Хуа Лу»: Течения Рек	56
А. В. Мешезников. Опыт реконструкции санскритских рукописей из Центральной Азии.....	64

НАУЧНАЯ ЖИЗНЬ

Т. В. Ермакова. Конференция «Актуальные проблемы буддологических и индологических исследований–17» (Санкт-Петербург, 17 июня 2024 г.)	80
И. В. Кульганек, Д. А. Носов. Седьмая международная конференция «Культурное наследие монголов: рукописные и архивные собрания» (Санкт-Петербург, 21–22 апреля 2025 г.)	83

RUSSIAN ACADEMY OF SCIENCES
Institute of Oriental Manuscripts
(Asiatic Museum)



191181, Russian Federation
Saint Petersburg,
Dvortsovaya Emb., 18
Phone: +7 (812) 315-87-28
<http://orientalstudies.ru>
mongolica@orientalstudies.ru
kulgan@inbox.ru
dnosov@mail.ru

MONGOLICA

Saint Petersburg journal for Mongolian studies

Vol. XXVIII • 2025 • No. 2

The journal is published four times a year.

Published since 1986

Founder: Federal State Institution of Science
Institute of Oriental Manuscripts of the Russian Academy
of Sciences

Editorial board:

I. V. Kulganek — *editor-in-chief, Dr. Sci. (Philology), Russian Federation*
D. A. Nosov — *secretary, Cand. Sci. (Philology), Russian Federation*
M. A. Kozintcev — *assistant secretary, Cand. Sci. (History), Russian Federation*
G. Bilguudei. *Dr. Sci. (Philology), Mongolia*
A. Birtalan. *Ph. D., Hungary*
S. Chuluun. *Academician of the Mongolian Academy of Sciences, Mongolia*
L. S. Dampilova. *Dr. Sci. (Philology), Russian Federation*
J. Legrand. *Dr. Sci., Professor, France*
V. Kapishovska. *Ph. D., Czech Republic*
E. E. Khabunova, *Dr. Sci. (Philology), Russian Federation*
N. Khishigt. *Ph. D. (History), Mongolia*
E. Munkhtsetseg. *Cand. Sci. (Philology), Mongolia*
S. L. Neveleva. *Dr. Sci. (Philology), Russian Federation*
K. V. Orlova. *Dr. Sci. (History), Russian Federation*
M. P. Petrova. *Ph. D. (Philology), Russian Federation*
R. Pop. *Ph. D., Romania*
Ts. Sarantsatsral. *Dr. Sci. (Philology) Mongolia*
T. D. Skrynnikova. *Dr. Sci. (History), Russian Federation*
R. M. Valeev. *Dr. Sci. (History), Russian Federation*
N. S. Yakhontova. *Cand. Sci. (Philology), Russian Federation*
I. V. Zaytsev. *Dr. Sci. (History), Professor of the Russian Academy of Sciences, Russian Federation*

ISSN 2311-5939

DOI 10.48612/IVRRAN/u242-79fv-7bdr

© Institute of Oriental Manuscripts RAS
(Asiatic Museum), 2025
© Group of authors, 2025

IN THIS ISSUE:

PHILOLOGY

- D. Gerelmaa.** Observing the Vocabulary in the Letters of the 18th-century Nobles, Princes, and Monks 5
- Li Qingjie.** The Study of the Heroic Epic about Geser by Soviet and Russian Scholars in the 20th Century 13
- E. Munkhtsetseg.** Mongolian Explanatory Dictionary Compiled by B. Buyanchulgan (1930) 20
- N. S. Yakhontova.** The Term *törö* in the Mongolian and Oirat Versions of the “History of Usun Debesgertu-khan” 28
- L. A. Fedotova, I. N. Khrapova, N. V. Yampolskaya.** Buddhist Artefacts in the Collection of the Central Scientific and Technical Library for Construction and Architecture 38

RELATED DISCIPLINES

- I. A. Alimov.** “Dong Jing Meng Hua Lu”: Rivers’ Course 56
- A. V. Mesheznikov.** Attempt of a Reconstruction of Sanskrit Manuscripts from Central Asia 64

ACADEMIC LIFE

- T. V. Ermakova.** The 17th Conference “Current Issues of Buddhological and Indological Studies” (St. Petersburg, June 17, 2024) 80
- I. V. Kulganek, D. A. Nosov.** The Seventh International Conference “Cultural Heritage of the Mongols: Manuscript and Archival Collections” (St. Petersburg, April 21–22, 2025) 83

Дагийн Гэрэлмаа
Чингис хаан Үндэсний музей

18 ДУГААР ЗУУНЫ НОЁД, ТАЙЖ, ЛАМ НАРЫН ЗАХИДЛУУДЫН ҮГСИЙН САНГ АЖИГЛАХ НЬ

Монгол улсын Архивын Ерөнхий газарт хадгалагдан буй 1748–1927 оны үеийн Монгол, Буриад, Алтайн Урианхай, Өвөр Монгол, Төвөдийн ноёд, лам нарын хоорондоо харилцсан зарим захидал бичгүүдийг Архивын Ерөнхий газрын эрдэм шинжилгээний ажилтан Б. Ринчинноров, Г. Сэр-Од нар эмхэтгэж “Ноёд, тайж, лам нарын захидлын цуглуулга: баримт бичгийн эмхэтгэл”-ийг 2019 онд хэвлүүлсэн билээ. Уг эмхэтгэлд Манж Чин улсын үеийн 214, Богд хаант Монгол Улсын үеийн 225, Ардын засгийн үеийн 22 буюу нийт 463 ширхэг ноёд, тайж, лам нарын захидлын цуглуулга нийтлэгджээ. Энэхүү өгүүлэлдээ уг эмхэтгэлд орсон захидлуудын үгийн санг ажиглаж, эдүгээ утга хэрэглээний хувьд явцуурсан буюу хуучирсан үгсийг түүн шинжлэхийг зорилоо. Эдгээр хуучирсан үгсийг монгол, хятад, төвөд, манж, орос-европ хэлний үгс хэмээн ангилаад тус бүрийн утгыг товч тайлбарлалаа. Мөн эдгээр эх захидлууд нь түүхийн чухал баримт төдийгүй захидал харилцагдаж буй тухайн цаг үеийн захидал харилцааны уламжлалт дэг, найруулга зүй, нийгмийн хөгжлийн онцлогийг тусгасан аман яриа, бичгийн үгсээр бичигдсэнээрээ онцлог бөгөөд түүхэн хэлшинжлэлийн чухал ач холбогдолтой судлагдахуун билээ. Эдгээр захидлууд бичгийн хувьд ихэвчлэн хичээнгүй тигээр бичигдсэн бийрийн захидлууд байна. Найруулгын хувьд албан хэргийн захидал, хувийн захидал, өргөх захидал бичгүүдээс бүрдэж байна.

Түлхүүр үг: 18 дугаар зуун, захидлууд, Үгийн сан, хуучирсан үгс, монгол үгс, хятад үгс, төвөд үгс, манж үгс, орос-европ үгс.

Зохиогчийн тухай: Дагийн ГЭРЭЛМАА, бакалавр, эрдэм шинжилгээний ажилтан, Чингис хаан Үндэсний музей (Монгол Улс, Улаанбаатар) (gerlee1272@gmail.com).

© Гэрэлмаа Д., 2025

Аливаа хэлний үгийн санд тодорхой цаг үед хэрэглэгдэж байсан боловч нийгмийн хэрэглээнээс шалтгаалж хэрэглэгдэхээ больсон үгс байдаг [Баттөгс, Пүрэвжав, Түвшинтөгс, Гэрэлмаа, Шинэбаяр, Ганболд, 2020. Х. 193]. Эдүгээ ард нийтийн ихэнх нь ойлгохоо больсон, утга хэрэглээ нь явцуурч хумигдсан, үгийн язгуур нь ойролцоо үг хийгээд бичгийн хэл, нутгийн аялгуунд үлдсэн, толь бичигт бий боловч хэрэглэгдэхээ больсон зарим хуучирсан үгсийг түүвэрлэн авахыг зорилоо. Хэлшинжлэлд хуучирсан үгийг хуучин үг, түүхэн үг гэж хоёр ангилдаг. Түүхэн үг хэллэг нь нэгэнт, хэлэнд түүнийг ямар нэг байдлаар орлох ойролцоо утгатай үг байхгүй учир тухайн цаг үед бодитойгоор оршин байсан юм үзэгдэл болон ойл-

голтыг нэрлэх гол үүрэгтэй байдаг бол хуучин үгийн ийм үүрэг нь гол бус, харин найруулгын үүрэг давамгайлдаг хэмээн утга, үүрэг, хэрэглээний ялгаатай байдлыг тодорхойлсон байна. Өөрөөр хэлбэр хуучирсан үг хэллэгийн нэгэн гол онцлог бол тухайн цаг үеийн түүхэн юм, ухагдахуун, хэлний тэмдгийг санагдуулна [Баттөгс, Пүрэвжав, Түвшинтөгс, Гэрэлмаа, Шинэбаяр, Ганболд, 2020. Х. 196] хэмээжээ. Эдгээр захидлын үгсийн санг монгол, хятад, манж, төвөд, орос-европ хэлний үгс хэмээн ангилаад, нийтдээ 75 хуучирсан үгсийг түүн шинжлэн авч үзлээ. Эл түүн авсан үгсээ галиглахдаа эх захидалд байгаа хэлбэрээр нь үндсэн илтгэлийн хэсэгт галиглаж бичив. Харин хавсралтад тухайн үгийн эх хэлэндээ зөв хэлбэрээр нь галиглан бичлээ.

Монгол хэлний үгс

Аливаа хэлний үгсийн үндсэн санг тухайн хэлний хамгийн тогтвортой буюу уугал үгс бүрдүүлдэг. Тэдгээр нь он цагийн шалгуурыг туулж хөдөлбөргүй хэвшин тогтож чадсан, шинэ үг бүтэж хөгжихөд үндсэн суурь хэрэглэгдэхүүн болдог, нийт ард түмний мэддэг, чухал хэрэгцээт үг байна [Дэмчигмаа, 2013. Х. 21]. Эдгээр захидлуудын үгсийн сангийн дийлэнх хувийг эх хэлний уугуул үгс эзэлж байна.

Манж Чин улсыг түшиж байсан тухайн үед идэвхтэй хэрэглэгдэж байсан улс төр, засаг захиргааны нэгж, албан тушаалтай холбогдолтой *эрийн төөлүүр данс* [er-e-yin tögölügüür dangsa] сумын насанд хүрсэн эрчүүдийн бүртгэл данс [Чулуунпүрэв, 2018. Х. 509], *сум эр* [sumu er-e] төөлүүр дансанд бүртгэгдэж алба татвар төлөх хүн, *хүнд* [kündü] хошууны суман зангийн туслах тушаалтан, *тамгын газрын сурц алба* [tamaγ-a-yin γajar-un surča alban], *тогосын отго* [toyus-un otuy-a], *улаа тэгшигтгэх* [ulay-a tegsidkekü] манжийн үеийн улаа өртөөний ажил албыг хуваарилж оногдуулах, *есөн өргөх* [yisün ergükü] манжийн хаанд өргөдөг есөн цагаан алба, *хэрмэлийн жасаа* [kerümel-ün jisiy-a] гэх мэт үгс орчин цагт хэрэглэгдэхүүн, ойлголтгүй болж түүхэн үгс болжээ. Эдлэл хэрэглэлийн зүйлсэд *тугдам* [tuydum] орд, өргөө [Төмөртоогоо, 2018. Х. 255], *бороон торго* [boruyan torγ-a] бороо нэвтэрдэггүй торго бололтой, *нэхмэл сур*, *дэвэр* [debür-e] шингэн зүйл агуулах гүц хэлбэртэй сав, *хос гэгээ зэвсэг* [qous gege jebseg] эмэгтэй хүний эдлэл бололтой, *товь малгай* [tobi malaya] дуулганы дотуур давхарлан өмсөх малгай гэх мэт хуучирсан үгс эдгээр захидалд тэмдэглэн үлджээ. Орчин цагт тэр бүр хэрэглэгдэхээ больсон *гудас* [γudus] дагуу, уруугаа [Төмөртоогоо, 2018. Х. 79] хэмээх үг МНТ-д “зоо гудас, Эрчис гудас” гэж хоёр удаа тохиолддог бол эдгээр захидлуудад зөвхөн “зам, замын” хэмээх үгтэй хоршоо хэлбэрээр нэлээд тохиолдож байна.

Монгол хэлний үйл үгийн язгуур морфем нь үгийн сангийн утгаа харьцангуй

тогтвортой хадгалж үлдсэн байдаг тул зарим хуучирсан үйл үгийн утгыг язгуур нэг бүлэг үгсээс нь мэдэх боломжтой. Жишээлбэл: *Мэндүүрэх* [mengdegüürkü] мэндэх, сандрах, *шилдэж* [sildekü] шилрэх, үл хайхран зайлах, *өгчилгөх* [ögčilegekü] өгөх, *тонирох* [ftoniraqui] тонилох, өнгөрөх, *дүлэвдэх* [dülbedekü] дүлэгнэх, *гачлах* [γačilaqu] дутах гачигдах, *хоног хугацаж* [qonuy quyučaqu] хоног хугацаа хугаслаж хэмнэж гэх мэт зарим хуучирсан үгсийг дурдаж болох юм. Мижид гүнгийн Да жанжинд бичсэн Шинжааны исламын шашинт хотон нар монголын баруун хязгаарын ард иргэдийг тонон дээрэмдэж их хохирол учруулсан тухай захидалд хуйхуй гэхээс гадна “муу хулгай хойс” хэмээн хотон нарыг тэмдэглэсэн бол мөн *хасуй цэрэг* [qasui čerig] гэж нэгэн овог аймгийн нэр бололтой үг тэмдэглэгджээ.

Хятад хэлний үгс

Монгол хятад хоёр үндэстэн олон мянган жил айл хөрш оршин сууж, аж ахуй, шашин соёл, улс төрийн харилцаатай байсан учир хятад хэлний үг монгол хэлэнд зохих хэмжээгээр нэвтэрсээр иржээ. Ялангуяа Чин улсын үед монгол, хятад хоёр угсаатан 200 шахам жилийн турш дахин нэгэн төрийн захиргаанд багтаж, олон талын харилцаатай байсан учир засаг захиргаа, хэргэм зэргийн холбогдолтой олон тооны хятад үг манж хэлээр дамжин монгол хэлний үгсийн санд орж иржээ. Түүнчлэн хятад иргэд монгол газар суурьшин сууж, газар тариалан, арилжаа наймаа, аж ахуй эрхэлж байсан учир идээ ундаа, жимс ногоо, худалдаа арилжаа, эд бараа, гэр ахуй, барилга байшин, багаж хэрэгсэл, хувцас хунарын холбогдолтой олон арван үг монгол хэлэнд нэвтрэн оржээ. Тэдгээр үгсийн олонх нь монгол ахуй соёлд шинэ тутам нэвтэрсэн ажил мэргэжил, алба тушаал, эд зүйлс зэргийг орлуулан нэрлэх монгол үг ховор байсан учир хятад хэлний нэрлэлт нь монгол хэлний орчинд идээшин зохицжээ [Төмөртоогоо, 2022. Х. 381–382].

Хятад гаралтай үг монгол хэлэнд их төлөв аман яриагаар орж ирж байсан тухай судлаачид тэмдэглэсэн буй [Дэмчигмаа, 2013. Х. 73].

Манжийн эзэн хаан болон хааны гэр бүлийнхнийг нэрлэх *хуанди* [huándi] эзэн хаан, *хуан тайху* [huwang tayiheu] эзэн хааны эх, *хунтайж* [huáng tài zi] хааны агь гэх мэт, төрийн албан тушаалын хэргэм зэрэг *дайфу* [dayifu] бага дунд зиндааны цэргийн эрхтэн [Гэрэлбадрах, 1999. Х. 24], есөнэрдэнийн ганжуур бүтээхбэхбэлтгэхэд хэрэглэгдэх есөн эрдэнэтэй холих *бээжин таригин* [begejin tarikin] хэмээх шавар, судар бичигтэй холбоотой *янбуу бичиг* [yangbuu bičig] мөнгөн цааст бичиг, үстэй бийрийг нэрлэсэн *мообин* [moobin] зэрэг үсэг бичиж ном хэвлэхэд тохиромжтой нэгэн төрлийн цаас [Мөнхсайхан, 2014. Х. 192–193], *гуутуур* [yutuur] бар хэвлэх болон бичиг үйлдэх цаасыг олон хувь хэвлэхэд зориулсан хэв [Мөнхсайхан, 2014. Х. 164], *хуа* [quva] зураг, *улааны пiao* [piào] улаа өртөөний тасалбар [Мөнхсайхан, 2014. Х. 197], *хуаминг* [quvaming] зэвсгийн жагсаалт бичиг гэх мэт үгс, идээ ундаа эд хэрэглэгдэхүүнтэй холбоотой *шуусаа* [šuuza] ногоо, эд хэрэглэгдэхүүн бөс даавуутай холбоотой *шанз торго* [sangji] шанз [олсоор хийсэн торго, *хунз* [qunza] цайны сав, мөнгө төгрөг арилжаа наймаатай холбоотой *шонхуйтан* [šongquyitan] 1913 онд гарсан Дундад иргэн улсын ерөнхийлөгч Юань шикайн дүрстэй долоон цэнгийн мөнгөн төгрөг [Мөнхсайхан, 2014. Х. 173], *янчаан* [yangciyan] хятад зоос зэрэг үгс, мөн хэмжүүр заасан *му* [mu], *пун* [fen], *ли* [li], *ху* [hu], *дэү* [duu] гэх мэт хятад үгс ноёд, тайж, лам нарын захианд дурдагдаж байна. Мөн Англи улсыг *Ин* [yīng] хэмээн бичжээ.

Төвөд хэлний үгс

Монгол Төвд хоёр орон улс төр, шашны өргөн харилцаатай байж Монголын хаад ноёд Сажа, Гармава урсгалын лам нарыг урин залж бурхны шашныг дэлгэрүүлэхийн

сацуу олон тооны ном судрыг санскрит төвд хэлнээс эх хэлнээ орчуулгаж, төр улсаа хос ёсны сургаалаар удирдан засахыг эрхэмлэж байжээ. Үүний хэрээр санскрит, төвд хэлнээс монгол хэлнээ шашин соёлын нэр томъё, үг хэллэг орсоор иржээ. Ялангуяа Монгол оронд бурхны шашин гурав дахь удаагаа дэлгэрсэн XVI зуунаас хойш Богд Зонховын үндэслэсэн шарын шашин буюу гэлүмбагийн ёс хүчтэй дэлгэрсэнтэй холбоотойгоор төвд хэл монголын утга зохиолын хэлтэй эн зэрэгцэх үүргийг гүйцэтгэх болж, санскрит төвд үгсийг тэмдэглэх галиг үсэг шаардагдсанаар 1587 онд Харчины Аюуш гүүш Али гали үсгийг зохион Ганжур, Данжур хөлгөн судруудыг монгол хэлээр орчуулах их ажлыг өрнүүлсэн билээ. Энэ л үеэс эхлэн төвд үг монголын бичгийн болон аман ярианы хэлэнд олноор орсон байна [Дэмчигмаа, 2013. Х. 70].

Албан тушаалтай холбоотой: *дэмч* [demči] хошууны сангийн хэрэг ажлыг эрхлэх хүний тушаал, ном бүтээхтэй холбоотой: *ранжун рад* [rangjung rada], *янлиг тиг* [yanlig tiy], бурхан шашны зан үйл, лам нартай холбоотой *жамжиг* [jamjiy] нэр хүнд, алдар, *сунтаг* [suntay] тарни тогтоолын утас, *гомбо* [yombo] чөлөө, эдлэл хэрэглэгдэхүүнтэй холбоотой: *сэвэг цай* [sebüg čai] сагс буюу цайны хэмжээ, хүндэтгэлтэй холбоотой: *лагшин биеийг нь шицог зандан* [šingčog zandan], үг хэлийг нь сүндэв [sungdub] гэх мэт төвөд хэлний үгсээр захиандаа хүндэтгэлээ илэрхийлж бичсэн байна.

Манж хэлний үгс

Монгол, манж зүрчин хэл нь алтай язгуурын хэлэнд багтдаг бөгөөд эртнээс хөрш зэргэлдээ байсан тул манж хэлнээс монгол хэлэнд, монгол хэлнээс манж хэлэнд олон үг орсон байна. Жишээлбэл: захидлуудад *фүжин* [fujin] хатан хэмээх үг олон тохиолдож байна. Мөн XVII зууны үед Монгол улсын хад ноёд өөр хоорондоо тэмцэлдэн бутралдаж, улс

орны байдал тогтворгүйтсэн тул тухайн үед хүчирхэгжиж байсан Дайчин гүрнийг түшиж, дагаар орсноор улс төрийн эрх мэдлээ алджээ. Энэ үеэс улс төртэй холбоотой олон үг манжаас монгол хэлэнд зарим нь орчуулагдаж, зарим үгс нь шууд орсон байна. Тухайлбал: *хувийн сайд* [quubi-yin sayid], *хэбэй түшээ* [kebei tüsiyi-e] зөвлөх, *дооль түшмэл* [dooli tüsimel] байцаан шүүгч түшмэлийн доодох албан тушаалтан, *үхэри да* [uheri da] бүгдийн дарга буюу хошууны захирагч, *гусай* [yusai] хошуу буюу хошууны сайд, *галай да* [yalai da] гарын дарга буюу ноёны дагуул, хиатай тэнцэх манж албан тушаалын нэр, *боодаа* [booī da] гэрийн дарга буюу ноёдын гэр орны аж ахуйг эрхэлж орон байрыг хариуцагч гэх мэт улс төр, засаг захиргаа, албан тушаал, мөнгө санхүүтэй холбоотой олон үгс манж хэлнээс орж иржээ. Мөн ноёд тайж нар захидал, харилцсан бичгээ сайн өдөр, сайн бэлгэт өдөр, өлзийт өдөр зэрэг монгол үгсээс гадна *ниулхүн* [niulkun] хийморь дэлгэрсэн өдөр гэх мэт манж үгсээр төгсгөсөн байна.

Орос, европ хэлний үгс

XX зууны эхээр Манж Чин улсын байдал сулран доройтох болсноор монголчууд тусгаар тогтнолынхоо төлөө тэмцэж Орос зэрэг гадаад улсуудтай илүү идэвхтэй харилцаж эхэлжээ. Энэ үеэс Оросоор дамжин орос европ хэлний зэр зэвсэг, техникийн холбогдолтой олон үгс орж иржээ. Техниктэй холбоотой *маузер* герман бууны марк, пулемёт [fulimad], *фонопор* [fonobor] мэдээ дамжуулах багаж хэрэгсэл, *телефон* [tilibon] цахилгаан утас, албан тушаалтай холбоотой *консул* [konsul] төлөөлөгч, *майорын зэрэг* [mayor-un jerge] хошууч, мөнгө төгрөгтэй холбоотой цөлхоов цаас [cölkoob] оросын хуучны цаасан мөнгө гэх мэт үгс эдгээр захидлуудад тэмдэглэгджээ.

Монгол улсын үндэсний төв архивд хадгалагдаж буй 1748–1927 оны үеийн Монгол Буриад, Алтайн Урианхай, Өвөр

Монгол, Төвөдийн ноёд, лам нарын хоорондоо харилцсан захидлуудын цуглуулга нь хэл бичиг, соёл ба түүхийн үнэтэй мэдээллийг агуулсан чухал эх сурвалж юм. Мөн эдгээр эх захидлууд нь түүхийн чухал баримт төдийгүй захидал харилцаж буй тухайн цаг үеийн захидал харилцааны уламжлалт дэг, найруулга зүй, нийгмийн хөгжлийн онцлогийг тусгасан аман яриа, бичгийн үгсээр бичигдсэнээрээ онцлог бөгөөд түүхэн хэлшинжлэлийн чухал ач холбогдолтой судлагдахуун билээ. Эдгээр захидлууд бичгийн хувьд ихэвчлэн хичээнгүй тигээр бичигдсэн бийрийн захидлууд байна. Найруулгын хувьд албан хэргийн захидал, хувийн захидал, өргөх захидал бичгүүдээс бүрдэж байна. Зарим захидлын утгыг онцлон дурдвал: Жавзандамба хутагтын IV дүрийг тодруулах талаар, ганжуур их хөлгөн судрыг есөн эрдэнээр бүтээх хэрэглэгдэхүүнийг цуглуулах талаар, шинэ амбаныг угтах хүндэтгэлийн ёслолын талаар, хилс хэргийг цагаатгаж өгөхийг хүссэн талаар, хулгай дээрмийг олж шийтгэх, эд хөрөнгөө булаалгуулсан тул ивээн тэтгэхийг хүссэн зэрэг байна. Захидлын бүтцийн хувьд уламжлал дагуу захидлын эхэнд өөрийн нэрээ дурдаад “үг ману” гэж бичдэг шиг мөн адил өөрийн нэрээ дурдаад бичиг, захиа, захиа бичиг, өргөх бичиг эсвэл дүүгийн бичиг, ахын бичиг гэх мэтчилэн бичсэн байна. Мөн нэрээ дурдалгүй өргөх нь, өргөх бичиг, захиа бичиг гэх мэтчилэн бичигдсэн ч бас байна. Зарим захидлын төгсгөлд захидал бичигдсэн огноо байх боловч ихэвчлэн “сайн өдрөө”, “сайн өдөр” мөн манжаар ниулхүн гэж бичиж үлдээжээ.

Монгол хэлэнд орсон олон манж үг байдаг ч Манж Чин улсын захиргаанд байсан жилүүдэд хэбэй түшмэл, боида гэх мэт манжийн хаад, ноёдын угсаатнууд болон манжийн их, бага албан тушаалуудын нэрс нэлээд орж иржээ. Одоо цагт эдгээр үгс нь тухайн үеийг илэрхийлэх түүхэн үгс болжээ. Хятад үндэстэнтэй олон мянган жил хөрш зэргэлдээ оршиж, худалдаа арилжаа, улс төрийн харилцаатай

байснаас бүх л харилцааны маш олон үгс цаг үе бүрд орж ирж байжээ. Зарим үгс нь монгол хэлэнд идээшин зохицож хятад үг гэж ялгагдахааргүй болжээ. Богд Зонховын үндэслэсэн шарын шашин 16 дугаар зуунаас эхлэн монголчуудын дунд дэлгэрсний нөлөөгөөр бурхан шашны ном судар монгол хэлэнд ихээр орчуулж, түгээн дэлгэрүүлснээр төвд хэлний үгс олон орж иржээ. Зөвхөн номбичгийн хэл, хүний алдар нэр төдийгүй сэвэг цай, жамжиг гэх мэтээр энгийн үгтэл ард иргэдийн ярианд багагүй орж ирсэн байна. Богд хаант Монгол улс

тусгаар тогтнохтой холбоотойгоор эдийн засаг болон геополитикийн түвшинд Хаант орос болон Англи, Франц, Америкийн нэгдсэн улсуудтай харьцаж эхэлснээр орос, европ хэлний үгс ихээр орж ирэх болжээ. Тийм авч фонопор, телефон зэрэг үгсийг төмөр утас, цахилгаан утас, цахилгаан гэх мэтээр орчуулан хэрэглэж байжээ. Мөн эдийн засаг, бараа таваар, худалдааны харилцааны гол мөнгөн нэгжийг янчаан /хятад/, цөлхөөв /орос/, мөнгөн зоос /монгол/ нэршлүүдээр ашиглаж байжээ.

Үгсийн жагсаалт (архивд буй дансны дугаар, галигийн хамт)

Мугдам [tuydum] МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.404. Б.2. Эх. МУУТА. ТБА. ХМ.170, Д.1. ХН.494. Б.9. Эх.

Боодаа [booi da] МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.440. Б.41. Эх.

Бороон торго [boruyun torɣ-a] МУУТА. ТБА. ХМ.170. ХН.176. Д.1. Б.7. Эх.

Бээжин таригин [begejin tarikin] МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.362. Б.10. Эх.

Галай да [ɣala-i da] МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.395. Б.18. Эх.

Гачлах [ɣaɕilaqu] МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.328. Б.1. Эх.

Гомбо [dgongs pa] МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.320. Б.1. Эх.

Гудас [ɣudus] МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.25. Б.13. Эх.

Гусай [ɣusa-i] МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.506. Б.1. Эх.

Гуутуур [gōutiáoer] МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.320. Б.1. Эх.

Дайфү [dayifu] МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.370. Б.11. Эх.

Дооль түшмэл [dooli түsimel] МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.601. Б.13. Эх.

Дуутуурын ор [duutur] МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.413. Б.8. Эх.

Дүлэвдэх [dülbedekü] МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.32. Б.13. Эх.

Дүү [deu] МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.45. Б.7. Эх.

Дэвэр [deberi] МУУТА. ТБА. ХМ.170. ХН.176. Д.1. Б.7. Эх.

Дэмч [dem chi] МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.396. Б.4. Эх.

Есөн өргөх [yisün ergükü] МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.367. Б.9. Эх.

Жамжиг [skyabs 'jug] МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.511. Б.2. Эх.

Ин улс [yīng ulus] МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.464. Б.4. Эх.

Консул [qongsul] МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.125. Х.7-14. Эх.

Ли [li], МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.464. Б.4. Эх.

Майорын зэрэг [mayuur-yin jerge] МУУТА. ТБА. ХМ.170. Д.1, ХН.365, Б.2-4. Эх.

Мообин [máobiān] МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.320. Б.1. Эх.

Му [mü], МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.464. Б.4. Эх.

Мэндүүрмү [mengdegüürimüi] МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.221. Х.38-42. Эх. МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.400. Б.14. Эх.

Ниулхун [niulkun] МУУТА. ТБА. ХМ.170. Д.1, ХН.365, Б.2-4. Эх.

Нялмуур [nilamayur] МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.591. Б.29. Эх.

Өгчилгөх [ögčilegekü] МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.413. Б.2. Эх. МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.101. Б.4. Эх.

Пун [fèn], МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.370. Б.11. Эх.

Пулемёт МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.137. Б.6. Эх.

Ранжун рад [rangjung rada] МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.362. Б.10. Эх.

Сум эр [sumun-u er-e] МУУТА. ТБА. ХМ.170. ХН.176. Д.1. Б.7. Эх.

Сунтаг [sungtay] МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.58. Б.2. Эх.

Сүндэв [süngdüb] МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.362. Б.5. Эх.

Сэвэг цай [sig bu] МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.117. Б.1. Эх

Тамгын газрын сури алба [tamaγ-a-yin γajar-un surča alban], МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.378. Б.7. Эх.

Телефон МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.137. Б.6. Эх.

Товь малгай [tobi malaya] МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.582. Б.13. Эх.

Тогосын отго [toγus-un otuγ-a] МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.362. Б.13. Эх.

Тонирох [toniraqui] МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.222. Х.5-14. Эх.

Улаа тэгшиитгэх [ulay-a tegsidkekü] МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.223. Х.13-17. Эх.

Улааны пiao [piào] МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.364. Б.3. Эх

Ужилж тамхи [üjiliu] МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.378. Б.16. Эх.

Ухэри да [uheri da] МУУТА. ТБА. ХМ.170. ХН.176. Д.1. Б.3. Эх.

Фонопор [фонопора] МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.137. Б.6. Эх.

Фүжин [fujin] МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.612. Б.12. Эх.

Хасуй [qasui] МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.318. Б.7. Эх.

Хойсэ [qoise] МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.175. Б.17. Эх. МУУТА. ТБА. ХМ.170. ХН.176. Д.1. Б.7. Эх. МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.568. Б.1. Эх.

Хоног хугацаж [qonuy quyučaju] МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.474. Б.7. Эх

Хос гэгээ зэвсэг [qous gegege jebseg] МУУТА. ТБА. ХМ.170. ХН.176. Д.1. Б.7. Эх.

Хошууны хацавч [qosiγun-u qačabči] МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.107. Б.28. Эх.

Хөхүүлтрэв [köggühtarbai] МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.486. Б.4. Эх

Ху [háu], МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.464. Б.4. Эх.

Хуа [huà] МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.458. Б.14. Эх.

Хуаминг [huāmíng] МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.381. Б.10. Эх.

Хуан тайху [huáng tài hòu] МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.318. Б.41. Эх

Хуанди [huándi] МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.320. Б.1. Эх.

Хуаны түний, хуаны газар МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.356. Б.6. Эх. МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.378. Б.16. Эх. МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.370. Б.11. Эх.

Хунз [kuāng zi] МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.444. Б.12. Эх.

Хунтайж [huáng tài zi] МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.74. Б.38. Эх.

Хуувийн сайд [quubi-yin sayid] МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.125. Х.7-14. Эх.

Хүнд [kündü] МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.413. Б.7. Эх.

Хэбэй түшээ [hebe-i tüsiyi-e] МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.11. Б.9. Эх.

Хэрмэлийн жасаа [kerümel-ün jisiy-a] МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.521. Б.1. Эх

Цөлхоов цаас [целковый]. МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.376. Б.14-18. Эх.

Шанз торго [šangju] МУУТА. ТБА. ХМ.170. ХН.176. Д.1. Б.7. Эх.

Шилдэж [sildejü] МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.45. Б.7. Эх.

Шингэ [singge] МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.367. Б.9. Эх.

Шицог зандан [shing tshogs] МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.327. Б.1. Эх

Шонхуйтан [yuanshikāi] МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.318. Б.27. Эх.

Шуусаа [šuuša] МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.367. Б.9. Эх.

Эрийн төөлүүр данс [er-e-yin tögelegür dangsa] МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.105. Б.1. Эх.

Янбуу бичиг [yínbó] МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.222. Х.1-4. Эх.

Янчаан [yang qián] МУУТА. ТБА. ХМ.170. Д.1. ХН.495. Б.1. Эх.

Товчилсон үгс

МУУТА — Монгол улсын үндэсний төв архив

ХМ — хөмрөгийн дугаар

Д — дансны дугаар

ХН — хөмрөгийн нэгжийн дугаар

Б — баримтын дугаар

Ашигласан ном зүй

Bayatur 2005: *Bayatur D. Kitad mongyol toli. ündüsün-ü keblel-ün qoriy-a*, 2005.

Бадамдорж 2015: *Бадамдорж Д.* Монгол хэлний үгийн сангийн утгазүй. Улаанбаатар, 2015.

Баттөгс, Пүрэвжав, Түвшинтөгс, Гэрэлмаа, Шинэбаяр, Ганболд, 2020: *Баттөгс Ш., Пүрэвжав Э., Түвшинтөгс Б., Гэрэлмаа Г., Шинэбаяр О., Ганболд Д.* Монгол хэлний үгийн сан, найруулга судлал. Монгол хэл судлалын түүх. III боть. Улаанбаатар, 2020.

Гэрэлбадрах 1999: *Гэрэлбадрах Ж.* XV–XVII зууны монголын ноёд язгууртнуудын зэрэг дэвийн асуудалд. Улаанбаатар, 1999.

Дэмчигмаа 2013: *Дэмчигмаа О.* Субашидын монгол орчуулгуудын үгийн сангийн онцлог. Улаанбаатар, 2013.

Лувсандаш, Шархүү 1968: *Лувсандаш Г., Шархүү Г.* Манж монгол толь бичиг. Улаанбаатар, 1968.

Мөнхсайхан 2014: *Мөнхсайхан С.* Монгол хэлний хятад гаралтай үг. Соёмбо принтинг. Улаанбаатар, 2014.

Ринчинноров, Лонжид 2019: Ноёд, тайж, лам нарын захидлын цуглуулга: баримт бичгийн эмхэтгэл.

Эмхэтгэсэн Ринчинноров Б., Лонжид З. Мөнхийн үсэг. Улаанбаатар, 2019.

Сүхбаатар 2018: *Сүхбаатар О.* Монгол хэлний харь үгийн толь. Монсудар хэвлэлийн газар. Улаанбаатар, 2018.

Төмөртоого 2018: *Төмөртоого Д.* Монгол хэлний үгийн гаралын тайлбар толь. Адмон принт, Улаанбаатар, 2018.

Төмөртоого 2022: *Төмөртоого Д.* Түүхэн хэл зүй, Монгол хэл судлал V боть, Улаанбаатар, 2022.

Түмэнжаргал 2010: *Түмэнжаргал Д.* Монголын лам, ноёдын мянган захидал, цуврал III, IV дэвтэр. Улаанбаатар, 2010.

Чоймаа, Заябаатар 2017: *Чоймаа Ш., Заябаатар Д.* Дайчин гүрний Дотоод яамны монгол бичгийн гэрийн данс. Дагалга боть. Соёмбо принтинг, Улаанбаатар, 2017.

Чоймаа, Цэрэндорж, Мөнх-Учрал, Ганбат 2024, Дэлгэрэнгүй тайлбартай монголын нууц товчоон / Ред.: Чоймаа Ш., Цэрэндорж Ц., Мөнх-Учрал, Ганбат Л. Сэлэнгэ пресс. Улаанбаатар, 2024.

Чулуунпүрэв 2018: Монгол хэлний хуучин үгийн толь / Эмхэтгэсэн Чулуунпүрэв С., Монсудар хэвлэлийн газар. Улаанбаатар, 2018.

OBSERVING THE VOCABULARY IN THE LETTERS OF THE 18TH-CENTURY NOBLES, PRINCES, AND MONKS

Dagii GERELMAA
Chinggis Khaan National Museum

B. Rinchinorov and G. Ser-Od, researchers of the General Archives of Mongolia, have compiled some correspondences between Mongolian, Buriad, Altai Uriankhai, Inner Mongolian, and Tibetan princes and monks from 1748 to 1927 that has been stored in the General Archives of Mongolia. *A Collection of Letters of Nobles, Princes, and Monks: An Anthology of Documents* was published in 2019. The compilation includes 463 letters: 214 letters from the Manchu Qing Dynasty, 225 from the Bogdo Khanate period of Mongolia, and 22 from the People's Republic period. This article aims to observe the vocabulary of the letters of the collection and analyze the words that are now outdated or old-fashioned in terms of meaning and usage in modern language. These words are divided into Mongolian, Chinese, Tibetan, Manchu, and Russian-European words, and the meaning of each is briefly explained. In addition, these original letters are not only important historical artefacts, but they also reflect the characteristics of the chancellery correspondence tradition, stylistics, and social development of the period in which they were transmitted. Moreover, the spoken and written language is also special and important for historical linguistics. These letters are usually written in cursive handwriting with a brush. In terms of composition, there are official letters, personal letters, and letters of petitions.

Key words: the 18th century, letters, vocabulary, old words, Mongolian vocabulary, Chinese vocabulary, Tibetan vocabulary, Manchu vocabulary, Russian-European vocabulary.

About the author: **Dagii GERELMAA**, Bachelor of Art. Chinggis Khaan National Museum (Ulaanbaatar, Mongolia) (gerlee1272@gmail.com).

ИССЛЕДОВАНИЕ ПИСЬМЕННОЙ ЛЕКСИКИ В ПИСЬМАХ ТАЙДЖИ, НОЙОНОВ И ЛАМ XVIII ВЕКА

Дагийн ГЭРЭЛМАА

Национальный музей Чингис-хана

Целью данной статьи является изучение и анализ письменной лексики, устаревшей и вышедшей из употребления в современном языке на примере сборника «Собрание писем принцев, великих князей и лам: сборник документов», хранящегося в Главном Архиве Монголии, изданного в 2019 г. Б. Ринчинноровом и Г. Сэр-Одом. Данный сборник включал переписку между монгольскими, бурятскими, алтайскими, тибетскими князьями и ламами с 1748 по 1927 гг. Сборник включает 463 письма: 214 писем периода маньчжурской династии Цин, 225 – Богдоского ханства Монголии и 22 – Народной Республики Монголии. Эти оригинальные письма являются важными историческими документами, отражают особенности традиции канцелярской переписки, стилистики. По статусу письма различаются на официальные, личные и письма-прошения. Последние обычно написаны скорописью. В письмах употребляются слова на монгольском, китайском, тибетском, маньчжурском и русском и некоторых европейских языках.

Ключевые слова: XVIII век, письма, лексика, старые слова, монгольская лексика, китайская лексика, тибетская лексика, маньчжурская лексика, русско-европейская лексика.

Об авторе: Дагийн Гэрэлмаа, бакалавр, научный работник, Национальный музей Чингис-хана (Улан-Батор, Монголия) (gerlee1272@gmail.com).